

ГАДААДЫН ИРГЭН, ХАРЬЯАТЫН ГАЗРЫН ӨМНӨД БҮС ДЭХ ГАЗРЫН
ТАВДУГААР САРД ХИЙЖ ГҮЙЦЭТГЭСЭН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТАЙЛАН
/2018.04.26-2018.05.25/

2018 оны 05 дугаар
сарын 26-ны өдөр

Даланзадгад сум

Гадаадын иргэн, харьяатын газрын Өмнөд бүс дэх газар нь холбогдох хууль, дүрэм, журмыг үйл ажиллагаандаа мөрдлөг болгон 2018 оны 04 дугаар сарын 26-ны өдрөөс 2018 оны 05 дугаар сарын 25-ны өдрийн хооронд дараах ажлыг хийж гүйцэтгэлээ.

Нэг. Үндсэн үйл ажиллагааны хүрээнд:

1.1. Виз олголтын талаар:

Тайлант хугацаанд Засгийн газрын 2010 оны 338 дугаар тогтоолоор баталсан “Монгол Улсын виз олгох журам”-ын дагуу хилийн боомтод виз олгоход шаардлагатай бичиг баримтыг биедээ авч явсан нийт БНХАУ-ын 5 иргэнд зохих ангиллын визийг олгож төлбөрийг төрийн санд төвлөрүүлэн ажилласан. Үүнд:

- Нэг удаагийн гарах-орох /Single re-entry/-2

- Визийн шилжүүлэг-3

Гашуунсухайт боомт

- Нэг удаагийн гарах-орох /Single re-entry/-2

- Визийн шилжүүлэг-1

Шивээхүрэн боомт

- Визийн шилжүүлэг-2

Нийт 5 гадаадын иргэнд виз олгож, визийн хуудасны үнэ болох 36104 /гучин зургаан мянга нэг зуун дөрөв/ төгрөгийг Гадаадын иргэн, харьяатын газрын “Голомт банк”-ны 1320000114 тоот дансанд, тэмдэгтийн хураамжийн 312.000 /гурван зуун арван хоёр мянга/ төгрөгийг Өмнөговь аймгийн Татварын газрын 100110000941 тоот дансанд тус тус тушаалган ажилласан болно.

Виз хүчингүй болгосон талаар:

БНХАУ-ын 1 иргэний “В” ангиллын олон удаагийн визийг “Монгол Улсын виз олгох журам”-ын 5.3.3 дахь заалтыг үндэслэн хүчингүй болгосон.

Тайлант хугацаанд Гашуунсухайт, Шивээхүрэн боомтоор зорчсон БНХАУ-ын 392 иргэний баримт бичиг болон хөдөлгөөнд хяналт тавьж ажилласан. Үүнд:

Орох чиглэлд:1991

Гарах чиглэлд:1930

Гашуунсухайт боомт

- *Орох чиглэл -924*

- *Гарах чиглэл-892*

Шивээхүрэн боомт

- *Орох чиглэл – 1067*

- *Гарах чиглэл-1038*

1.2. Түр ирэгчийн бүртгэл, хасалт, оршин суух зөвшөөрлийн хасалт:

Тайлант хугацаанд 57 гадаадын иргэнд түр ирэгчийн бүртгэл, 1 иргэний хасалт хийж ажилласан байна.

ХОНЗҮ-ээр зорчигч гадаад иргэдийн хяналтын талаар:

Хил орчмын нутагт зорчих нэг болон олон удаагийн үнэмлэхтэй БНХАУ-ын 69 иргэнийг бүртгэж, 70 иргэнд хасалт хийж тухайн иргэдийн шилжилт хөдөлгөөн, Монгол Улсад байх хугацаанд хяналт тавьж ажилласан.

Гарын хурууны хээ, фото зураг авсан талаар: Тайлант хугацаанд Монгол Улсад хөдөлмөр эрхлэхээр ирсэн “Тавантолгой шин”, “Дарданговь”, “Буман айл”, “Саусгоби сэндс” ХХК-ийн БНХАУ-ын нийт 46 иргэний гарын хурууны хээ болон фото зургийг авч төвд хүргүүлсэн.

1.3. Хилийн чанад болон Гадаадын иргэн, харьяатын газарт алдаатай олгогдсон, зөвшөөрөлгүй олгогдсон визийг засварласан болон хүчингүй болгосон талаар:

БНХАУ-ын Бээжин хот дахь ЭСЯ-наас олгогдсон “НГ” ангиллын хоёр виз, Хөх хотын Консулын газраас олгосон “В” ангиллын 8 визийн хүчинтэй хугацааг тус тус алдаатай олгосон байсныг засварлаж, 28 дугаар бүхий визийн тэмдгээр баталгаажуулсан.

1.4. Албадан гаргасан талаар:

Монгол Улсын шүүхээр ял шийтгүүлсэн /Өмнөговь аймаг дахь сум дундын эргүүгийн хэргийн анхан шатны шүүхийн энэ оны 04 дүгээр сарын 16-ны өдрийн 78 тогтоол/ БНХАУ-ын иргэн Ма Минг /1969 оны 07 дугаар сарын 04-ний өдөр төрсөн, эрэгтэй, G606165141 дугаарын паспорттай/ -ийг Гадаадын иргэний эрх зүйн байдлын тухай хуулийн 37 дугаар зүйлийн 37.1.11 дэх заалт, Засгийн газрын 2010 оны 339 дүгээр тогтоолоор баталсан “Гадаадын иргэнийг Монгол Улсаас албадан гаргах болон Монгол Улсад дахин оруулахгүй байх хугацааг тогтоох журам”-ын 3.11, гадаадын иргэний хяналтын улсын байцаагчийн 11/63-09 дугаарын дүгнэлт, байгууллагын даргын 2018 оны 05 дугаар сарын 15-ны өдрийн А/179 дүгээр тушаалыг тус тус үндэслэн энэ оны 05 дугаар сарын 17-ны өдөр Шивээхүрэн авто замын боомтоор албадан гаргасан.

1.5. Монгол Улсын хилээр оруулаагүй буцаасан гадаадын иргэдийн талаар:

Гашуунсухайт, Шивээхүрэн авто замын боомтоор ГИЭЗБТХ-ийн 22.1.6 дахь заалт, мөн хуулийн 22 дугаар зүйлийн 22.1.6, мөн хуулийн 11 дүгээр зүйлийн 11.6 дахь заалт, Засгийн газрын 2010 оны 338 дугаар тогтоолоор баталсан “Монгол Улсын виз олгох журам”-ын 4.1 дэх заалтыг тус тус үндэслэн, ярилцлага хийж БНХАУ-ын 51 иргэнийг Монгол Улсын хилээр оруулаагүй буцааж ажилласан.

Хоёр. Удирдлага, зохион байгуулалтын хүрээнд:

2.1. Захиргааны чиглэлээр хийсэн ажил

Өмнөговь аймгийн Бүсийн оношлогоо эмчилгээний төвтэй хамтран албан хаагчдын эрүүл мэндийн урьдчилан сэргийлэх үзлэгийг энэ оны 05 дугаар сарын 22-

ны өдрөөс эхлэн зохион байгуулан ажиллаж байна. Үзлэгээр Элэгний В,С вирус, цусны дэлгэрэнгүй шинжилгээ болон чих хамар хоолой, мэдрэл зэрэг эмчийн иж бүрэн үзлэгт хамрагдаж байгаа юм.

Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлаг Удирдлагын академи, Өмнөговь аймгийн ЗДТГ-тай хамтран зохион байгуулсан “Иргэнд чиглэсэн төрийн үйлчилгээний чанарыг сайжруулах арга зам” сэдэвт нийт 16 цагийн сургалтад 2018 оны 05 дугаар сарын 21-ний өдрөөс 22-ны өдрүүдэд мэргэжилтэн Д.Эрдэнэбулган, Захиргааны ахлах мэргэжилтэн Ш.Дэмбэрэлдулам нар амжилттай оролцлоо.

Тус газрын шинээр баригдахаар төлөвлөж буй албаны орон сууцны шугам сүлжээ, мэдээлэл холбоо, ус хангамж, цахилгааны техникийн нөхцөл гаргуулах хүсэлт, шаардлагатай бичиг баримтыг бүрдүүлэн холбогдох газруудад энэ оны 05 дугаар сарын 24-ний өдөр албан бичгээр уламжлаад байна.

2.2. Өргөдөл, гомдлын мэдээ

- Бүртгэсэн өргөдөл, гомдлын тоо /Хүлээн авсан/- 1

- Шийдвэрлэсэн өргөдөл, гомдлын тоо- 1
- Шилжүүлсэн өргөдөл, гомдлын тоо /Ерөнхий газарт/-0
- Шийдвэрлэлтийн шатанд байгаа болон хугацаа сунгасан өргөдөл, гомдлын тоо-0
- Баримт бичиг боловсруулалтын хүрээнд /Тушаал-0/
- Ерөнхий газраас ирсэн бичиг-5
- Ерөнхий газарт явуулсан бичиг /албан тоот-0, илтгэх хуудас-8/
- Бусад байгууллагад хүргүүлсэн бичиг /албан тоот-17/
- Бусад байгууллагаас ирсэн бичиг-10
- Боомт орон нутагт явуулсан дотоод албан бичиг-1

2.3. Санхүү, хангалт үйлчилгээний ажлын талаар:

Тус Газрын 04 дүгээр сарын шилэн дансны мэдээллийг шивж, мэдээг Санхүүгийн хэлтэс, Дүн шинжилгээ, дотоод аудитын хэлтэст хүргүүлсэн.

Энэ оны 05 дугаар сард 18 албан хаагчид 12.000.000 төгрөгийн цалин олгож, татварт 1.200.000 төгрөг, нийгмийн даатгалд 3.798.533 төгрөгийн, хангамж бараа материалын зардалд 2.601.161 төгрөг, байр ашиглахтай холбоотой зардалд 1.456.366 төгрөгийн гүйлгээ хийж Өмнөговь аймгийн төрийн сангаар баталгаажуулан, өр авлаггүй ажилласан.

2.4. Мэдээлэл технологийн чиглэлээр:

Газрын хэмжээнд сүлжээний хэвийн байдлыг ханган, бүсийн хэмжээнд гарсан эвдрэл, гэмтлийг тухай бүр нь засч сайжруулан ажиллаж байна.

Мэдээллийн ил тод байдлыг ханган ажиллах үүднээс байгууллагын цахим хуудсанд тус газрын 2018 оны 04 дүгээр сарын төлөвлөгөө, 04 дүгээр сарын төлөвлөгөөний биелэлт, тайлан, үйл ажиллагааны мэдээ мэдээллийг тухай бүр байршуулж олон нийтийг мэдээллээр ханган ажиллаж байна.